



МОНГОЛ АРДЫН НАМД

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2017.05.10 № 920

танай _____ -ны № _____ -т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.18-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд танай намаас нэр дэвшигч Миеэгомбын Энхболдын сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдэгдэл

Монгол Ардын нам Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Төсвийн тогтвортой байдлын тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нийцсэн байдал, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг үнэн зөв гаргаж, нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тооцоо судалгаанд үндэслэн, найруулгын хувьд ойлгомжтой, хоёрдмол утгагүйгээр боловсруулан Үндэсний аудитын газарт ирүүлэх үүрэгтэй.

Монгол Ардын намаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээнүүд нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрт дүгнэлт өгөх нь Үндэсний аудитын газрын үүрэг юм.

Дүгнэлтийн үндэслэл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээг хянан үзэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн тооцооллыг шалгахдаа Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгон авч үзсэн болно.

Дүгнэлт

Нэг. Мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх талаар

Энэхүү дүгнэлтэд хавсаргасан Монгол Ардын намаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээнүүд нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн байна.

070344


000045

Хоёр. Мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаар
Энэхүү дүгнэлтэд хавсаргасан Монгол Ардын намаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан тодорхой санхүүжилт, эх үүсвэр шаардагдах зорилт, арга хэмжээнүүдийн санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг зохих ёсоор хянан үзэж, хангалттай гэж үзсэн болно.

Хувийг: Сонгуулийн Ерөнхий Хороонд

Хавсралт 6 хуудастай

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2017 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД МОНГОЛ АРДЫН
НАМААС НЭР ДЭВШИГЧИЙН ХӨТӨЛБӨР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД НЭР ДЭВШИГЧ
МИЕЭГОМБЫН ЭНХБОЛД МИНИЙ БИЕ

АРД ТҮМНИЙ ХҮСЭЛ ТЭМҮҮЛЭЛТЭЙ АМЬ НЭГ,
АЙЛ ГЭРИЙН ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭТЭЙ АГААР НЭГ,
АМИН УЛСЫНХАА АЖИЛ АМЬДРАЛТАЙ ХӨРС НЭГ

байх тулгын гурван чулуу мэт зарчимд тулгуурлан мөрийн хөтөлбөрийнхөө үзэл баримтлалыг
тодорхойлж, сонгогч танд өргөн барьж байна.

**ИРГЭН ТАНД, ТАНЫ ГЭР БҮЛД САНАА ТАВЬЖ, САНАЛЫГ ТАНЬ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА.**

Монгол Улсын хөгжил, дэвшлийн эх сурвалж нь эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх
орондоо хайртай иргэн Та юм.

Хүүхэд залуучуудаа амьдралд бэлтгэхэд нь, идэр насныхнаа амьдралаа дээшлүүлэхэд
нь, өтөл насныхнаа амьдралын чанараа хангаж, хамгаалахад нь миний бие хичээнгүйлэн
ажиллана.

Хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдэлж, төрийн бодлого иргэдийн саналд
тулгуурладаг, ардчилсан засаглалыг бэхжүүлэх төрийн бодлогыг манлайлахаа илэрхийлж
байна.

НЭГ. ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЭЛ, МОНГОЛ БАХАРХАЛ

- 1.1. **Эв нэгтэй Монгол.** Нийгмийн оюун санааны нэгдмэл байдлыг баталгаажуулах, эв нэгдэл,
итгэлцэл, ёс суртахууныг дээшлүүлэх, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх, үндэсний эв
зөийг бэхжүүлэх үзэл санааг мөрдлөг болгоно.
- 1.2. **Үнэт зүйлтэй Монгол.** Үндэсний бахархал, эх оронч үзлийг үнэт зүйлээ болгосон иргэн
төлөвшүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.
- 1.3. **Эв нэгдлийн суурь.** Хууль дээдлэх зарчим, шударга ёс, баялгийн тэгш хуваарилалт нь
үндэсний эв нэгдлийг хангах бат бэх суурь гэж үзнэ.
- 1.4. **Улс төрийн зэрэг соёл.** Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газрын тэнцвэртэй, харилцан
ойлголцсон улс төрийн зөвшилцлийг хуулийн хүрээнд хангаж иргэний нийгмийн
байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллана.
- 1.5. **Түмний төлөө төрийн бодлого.** Төрийн бодлого, үйл ажиллагаанд улс төр - бизнесийн
явцуу бүлэглэл нөлөөлөхийн эсрэг тууштай зогсож, ард түмний эрх ашгийг эн тэргүүнд
тавина.
- 1.6. **Хариуцлагатай улс төрийн нам.** Улс төрийн намын үйл ажиллагаа, санхүүжилтийг ил
тод, хяналттай болгох, улс төрийн намуудын төлөвшлийг хангах эрх зүйн шинэ орчин
бүрдүүлж төрийн өндөр албан тушаалтнуудад тооцох хариуцлагын тогтолцоог шинэчлэнэ.
- 1.7. **Хичээн дагах дүрэм.** Үндэсний уламжлалт арга барилд тулгуурлан хүүхдийг Монгол хүн
болгон төлөвшүүлэх дүрэм боловсруулж, мөрдлөг болгох зарлиг гаргана.
- 1.8. **Чөлөөт хэвлэл ардчиллын баталгаа.** Хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлаж буй аливаа
хуулийн зохицуулалтуудыг залруулж, нийгмийн хариуцлагаа ухамсарласан, хараат бус,
мэргэшсэн сэтгүүл зүйг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэн, нийгмийг соён гэгээрүүлэх
чиглэлд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллана.

ХОЁР. ХАРИУЦЛАГАТАЙ, ШУДАРГА, ТОГТВОРТОЙ ЗАСАГЛАЛ.

- 2.1. **Тэнцвэртэй, хариуцлагатай, тогтвортой төр.** Засаглалын төгөлдөршил, төрийн хариуцлага, хяналт тэнцлийг боловсронгуй болгох, тогтвортой байдлыг хангах шаардлагад үндэслэн Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг ард түмнээсээ асууж шийдвэрлүүлнэ.
- 2.2. **Мэргэшсэн төрийн алба.** Төрийн алба оновчтой бүтэцтэй, мэргэшсэн, чадварлаг, хариуцлагатай, тогтвортой ажиллах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн орчныг сайжруулна.
- 2.3. **Төрийн албан хаагчдын зөв хандлага.** Төрийн албан хаагчдыг зөв хандлагатай, ёс зүйтэй, сахилга хариуцлагатай, бүтээмжтэй болгох, ажлын арга барилын шинэ соёлыг бүх түвшинд хэвшүүлэх, тэдний ажиллах орчин, нийгмийн баталгааг сайжруулах бодлогыг тууштай дэмжинэ.
- 2.4. **Авилгагүй төрийн алба.** Авилга, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон албан тушаалтнуудын хэргийг ил тод шуурхай шийдвэрлэх, энэхүү гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг чангатгах, авилгын хэргээр ял шийтгэгдсэн этгээдийг төрийн албанд сонгож томилдоггүй байх эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 2.5. **Нийгмийн бүлгүүд – захиргааны шударга зарчим.** Төрийн албаны сонгон шалгаруулалт, томилгоо, байршуулах, сэлгэн ажиллуулах, дэвшүүлэх үйл явцад нийгмийн бүлгүүдийн төлөөллийг жигд хангах захиргааны шударга зарчмыг харгалзана
- 2.6. **Хариуцлагатай хууль сахиулагч.** Иргэдэд ялгавартай хандаж, хүний эрх зөрчсөн, мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргасан, гэмт хэрэгт холбогдсон нь тогтоогдсон бүх шатны шүүгч, прокурор болон бусад холбогдох албан тушаалтанд оногдуулах хариуцлагыг чангатгах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 2.7. **Хараат бус шүүх засаглал.** Хууль сахиулах болон шүүхийн үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг бүрэн хангуулж, улс төрийн нөлөөллөөс ангид байх зарчмыг чанд сахиулж ажиллана.
- 2.8. **Нөлөөлөлгүй шүүхийн захиргаа.** Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх, үүргийг нарийвчлан тогтоох замаар хууль дээдэлсэн, шударга, хариуцлагатай шүүхийг төлөвшүүлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- 2.9. **Шударга шүүгч – шударга шийдвэр.** Шүүгчдийг сонгон шалгаруулахад нөлөөллөөс ангид, мэргэшил, ёс зүй, зан суртахууны төлөвшлийг шалгуур болгох, шүүгч бүр дээр үнэлгээ өгөх, үүрэг хариуцлагыг сайжруулах хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 2.10. **Гэмт буруутан-бодит хариуцлага.** Бүс нутаг, олон улсын цагдаа хүчний байгууллагуудтай илүү нягт, идэвх уялдаатай хамтран ажиллаж улсад их хэмжээний хохирол учруулаад гадаадад оргон зайлсан этгээдүүдийг эрэн сурвалжилж, эргүүлэн эх оронд нь авчрах ажиллагааг дэмжиж ажиллана.
- 2.11. **Эзнээ олсон шагнал.** Ажил үйлс, авьяас чадвараа шударгаар, ил тод үнэлүүлэн шагнуулах боломжийг иргэн бүрт олгож, шагналын нэр хүндийг өсгөнө.

ГУРАВ. МОНГОЛ ХҮН ТА МОНГОЛЫН ҮНЭТ БАЯЛАГ

- 3.1. **Хүндээ чиглэсэн төрийн бодлого.** Иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, хүн амаа өсгөх, гэр бүлийн тогтвортой байдлыг хадгалах бодлогыг чухалчилна.
- 3.2. **Эрүүл мэндийн оновчтой бодлого.** Эрүүл мэндийн салбарын үйлчилгээг сайжруулж, санхүүжилтийн эх үүсвэрийг боловсронгуй болгон, менежментийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх бодлого санаачлан Засгийн газарт чиглэл болгоно.
- 3.3. **Хүнд хүрсэн эрүүл мэндийн үйлчилгээ.** Эрүүл мэндийн салбарын техник, технологи, орчныг сайжруулах, эмч ажиллагсдын ур чадвар, зөв хандлага, хариуцлага, үр дүнг чухалчлах бодлогыг дэмжиж, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхийг шаардаж ажиллана.
- 3.4. **“Монгол хүний эрүүл мэндийг урьдчилан хамгаалах”** Үндэсний хөтөлбөр шинэчлэн санаачилж, хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгоно.

- 3.5. **Эрүүл бие амжилтын үндэс.** Багийн, оюуны болон өвлийн спорт, нийтийн биеийн тамирыг түгээн дэлгэрүүлэхэд анхаарна.
- 3.6. **Өрсөлдөх чадвартай Монгол хүн.** Ерөнхий боловсролыг тогтвортой төрийн бодлогоор дэмжих, нэн ялангуяа байгалийн шинжлэлийн хичээлийг шинэ шатанд гаргах, Монгол хүний дэлхийд өрсөлдөх суурийг бэхжүүлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- 3.7. **Бодит сургалт** - танин мэдэхүй. Хүүхэд багачуудыг үндэсний соёл, Монгол дархлаатай иргэн болгон хүмүүжүүлэх, чөлөөтэй уран бүтээл туурвих, шинэ технологитой танилцан бодитоор сургалтанд хамрагдаж, туршлага хуримтлуулахыг дэмжинэ.
- 3.8. **Өв соёлтой Монгол.** Монголын түүх, соёлын биет болон биет бус өвийг хадгалан хамгаалах, сурталчилах үйл ажиллагааг ивээлдээ авч, музейн орчин, нөхцлийг олон улсын жишигт нийцүүлэх ажлыг дэмжинэ.
- 3.9. **Дэлхийн боловсролыг эх орондоо.** Олон улсын хэмжээнд үнэлэгдэх чанартай боловсролыг эх орондоо зардал багатай эзэмших боловсролын менежментийн тогтолцооны эрх зүйн орчныг сайжруулна.
- 3.10. **Гадаадад суралцах боломж.** Олон улсын нэр хүндтэй тэргүүлэх их дээд сургуульд элсэн суралцах боломжийг өргөжүүлнэ.
- 3.11. **Залуучуудын хөгжил.** “Залуучууд-ажил эрхлэлт”, “Залуучууд-орон байр”, “Залуучууд-бүтээлч хөгжил”, “Оюутан-дотуур байр” цогц хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгоно.
- 3.12. **Хөрөнгө оруулагч иргэн.** Иргэний боловсролыг дэмжин хүүхэд залуучуудад бизнесийн суурь боловсрол олгох санаачлага гарган хөрөнгө оруулагч иргэд бий болгоход анхаарна.
- 3.13. **Малчдаа дэмжих бодлого.** Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх, урамшуулах бодлогыг дэмжиж хууль, эрх зүйн орчинг сайжруулна.
- 3.14. **Хүртээмжтэй нийгмийн хамгаалал.** Өндөр настан, нийгмийн эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын талаарх Засгийн газрын бодлогыг дэмжиж, Монгол хүний үнэ цэнийг хадгална.
- 3.15. **Ур чадвар - нийгмийн баталгаа.** Боловсрол, эрүүл мэндийн ажилтнуудын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд онцгойлон анхаарна.
- 3.16. **Тэгш оролцоо.** Жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэх аливаа санал санаачлагыг дэмжинэ.
- 3.17. **Эх үрсийн бодлого.** Эхчүүдийн төрөхийн өмнөх, төрсний дараах болон хүүхдээ өсгөхөд шаардагдах нийгэм хамгааллын үйлчилгээг хүртээмжтэй болгох, эмэгтэйчүүдийн дунд элбэг тохиолдож байгаа хорт хавдрын эрсдэлийг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэгт 2 жил тутамд бүрэн хамруулах чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлж байгаа эх үрсийн бодлогыг бүх талаар дэмжиж ажиллана.
- 3.18. **Хилийн чанад дахь иргэдээ анхаарсан бодлого.** Гадаадад ажиллаж, амьдарч байгаа Монголчуудаа дэмжсэн, тэдний эрх ашгийг хамгаалсан Засгийн газрын бодлого, үйл ажиллагааг дэмжинэ.
 - Гадаадад ажиллаж, амьдарч байгаа Монголчууд, үр хүүхдүүд нь хэл, соёлоо хадгалах, суралцахыг дэмжинэ.
 - Гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн үүсгэл санаачилга, эх орондоо ирж ажиллах, хөрөнгө оруулалт хийхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.19. **Шинжлэх ухаан, технологийн дэвшил.** Шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг бүс нутгийн дундаж жишигт ойртуулах эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 3.20. **Судалгаа, хөгжлийн сан.** Технологи, мэдлэгийг бий болгох, импортлох тогтолцоог бүрдүүлэх зорилгоор төр, хувийн хэвшил хамтарсан аливаа санал санаачлагыг дэмжиж, шилдэг инноваторуудыг төр, бизнесийн салбарт ажиллуулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгоно.
- 3.21. **Эх орны дуудлага.** Дэлхийн шилдэг их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, компаниудад ажиллаж байгаа мэргэжилтнүүдээ урьж, ур чадварыг нь ашигладаг санаачилгыг өрнүүлнэ.
- 3.22. **Хотын хөгжил – улсын хөгжлийн гарц.** Нийслэл хотын хөгжлийг төлөвлөх, бодит ажил болгох, гүйцэтгэлд нь хяналт үнэлгээ хийхэд орон нутгийн засаг захиргаа, төрийн

УХА

байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгэм, иргэдийн хамтын оролцоог дэмжиж, хотын хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

- 3.23. **Шинэ суурьшил – бүтээн байгуулалт.** Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, суурьшлын шинэ бүс, дагуул хот бий болгох, Хөшигийн хөндийг дагасан шинэ бүтээн байгуулалтыг дэмжинэ.
- 3.24. **Төмөр замын шинэ чиглэл.** Улаанбаатар хотын тээврийн хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, хүн, ачаа тээврийн шинэ чиглэл бий болгох зорилгоор хотыг тойрон гарах төмөр зам барих Засгийн газрын үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.

ДӨРӨВ. БАЯЛАГ БҮТЭЭГЧ ДУНДАЖ ДАВХАРГА

- 4.1. **Өрсөлдөх чадвартай дундаж давхарга.** Бүтээлч, өрсөлдөх чадвартай, бүтээмжтэй, нийгэм эдийн засгийн аливаа эрсдэлийг даван туулах чадамжтай нийгмийн дундаж давхаргыг өргөжүүлэх бодлого баримтална.
- 4.2. **Өсөлттэй, тогтвортой эдийн засаг.** Эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн УИХ-ын бодлого, Засгийн газрын үйл ажиллагааг тууштай, идэвхтэй дэмжиж, үр дүн, хяналтыг чухалчлан ажиллана.
- 4.3. **Үндэсний бүтээмж.** Судалгаа шинжилгээнд суурилсан, өөрийгөө тэтгэх чадвартай эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалтыг татах, олон улсын зах зээлд гарах, өрсөлдөх чадвартай дотоод нөөц бололцоондоо тулгуурласан эдийн засгийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд анхаарна.
- 4.4. **Итгэлцэл - хөрөнгө оруулалт.** Эдийн засгийн суурь үзүүлэлтийг сайжруулах, Монгол улсын зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэх, улс төр, эдийн засгийн тогтвортой бодлогоор гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогыг дэмжинэ.
- 4.5. **Төрөлжсөн эдийн засаг.** Монгол улсын эдийн засгийн уул уурхайн салбараас хэт хамаарлыг бууруулах чиглэлээр хөдөө аж ахуй, аялал жуулчлал, үйлдвэрлэл, эрчим хүчний салбарыг дэмжих бодлогыг бодит ажил болгохыг Засгийн газраас шаардаж ажиллана.
- 4.6. **Шинэ үйлдвэржилтийн бодлого.** Импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх хувийн хэвшлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тулгуурлан валютын урсгалыг нэмэгдүүлэх үйлдвэржилтийн бодлогыг тэргүүн ээлжид анхаарна.
- 4.7. **Тэргүүлэх технологийн бүтээгдэхүүн.** Нүүрс боловсруулах, нийлэг хий, нефтийн бүтээгдэхүүн гаргах, мэдээллийн технологи, ХАА-н чиглэлээр дэлхийн тэргүүлэх технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, эдийн засгийн эргэлтэд оруулах төслийг дэмжиж, УИХ, Засгийн газарт чиглэл болгоно.
- 4.8. **Эрчим хүчний экспорт.** Эрчим хүчний хэрэгцээг дотоодын найдвартай, тогтвортой эх үүсвэрээс бүрэн хангах, цахилгаан эрчим хүч экспортлох, сэргээгдэх эрчим хүч ашиглах төрийн болон хувийн хэвшлийн санаачилга, ажил хэргийг дэмжиж ажиллана.
- 4.9. **Үнэд хүрсэн баялаг.** Уул уурхайн болон дагалдах дэд бүтцийн томоохон төсөл дэх төр, иргэдийн оролцоог оновчтой болгох, төслүүдийг цаг алдахгүй эхлүүлэхэд анхаарч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллана.
- 4.10. **Хуримтлалын сан.** Одоо болон ирээдүй хойч үеийн хөгжлийг дэмжих “Ирээдүйн өв сангийн тухай” хуулийг хэрэгжүүлэхийг шаардаж ажиллана.
- 4.11. **“Эдийн засгийн коридор”** хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллана.
- 4.12. **Шинэ хөдөө.** Хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах, атрын аяны хүрсэн түвшинг ахиулах, малын гаралтай түүхий эдийн үнийг тогтворжуулах бодлогыг дэмжинэ. Мал сүргийн удмын санг хамгаалах, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зорилгоор улсын мал эмнэлгийн тогтолцоог сэргээн хөгжүүлэх талаар Засгийн газарт чиглэл хүргүүлнэ.
- 4.13. **Орон нутгийн хөгжил.** Хот хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгаж бүсийн төвүүдийн хөгжил, бүтээн байгуулалтыг эрчимжүүлэн хөдөө орон нутагт ажиллаж, амьдарч буй иргэдийг дэмжих эрх зүйн орчин бүрдүүлнэ.

- 4.14. **Жижиг дунд үйлдвэрлэл – шинэ ажлын байр.** Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн нэгдмэл байдлыг хангах, инновацийг хөгжүүлэх ажлыг бодлогоор дэмжин, ажлын байрыг тогтвортой нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.
- 4.15. **Гарааны бизнес.** Гарааны бизнесийг төрийн бодлогоор дэмжих, их, дээд сургуулиудын үйл ажиллагааг хувийн хэвшлийн салбарын хэрэгцээ, шаардлагатай уялдуулах, судалгаа - хөгжлийн ажлыг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 4.16. **Хөрөнгийн зах зээлийн шинэчлэл.** Компаниудыг олон нийтийн хувьцаат компани болгохыг дэмжиж, эрх зүйн орчинг сайжруулна.
- 4.17. **Оффшор бүсээр бус Монголоор.** Санхүүгийн тогтолцоог эрүүл өрсөлдөх чадвартай болгож, гадаад, дотоодын хөрөнгө санхүү Монгол улсаар дамжих үйлчилгээг бодлогоор дэмжинэ.
- 4.18. **Үр ашигтай төрийн өмч.** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглалыг сайжруулж, үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг ханган эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлогыг тууштай баримтална.
- 4.19. **Бүсчилсэн аялал жуулчлал.** Аялал жуулчлалыг бүс нутгийн онцлогт тохируулж бүсчлэн хөгжүүлэх, орон нутгийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүхий л үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 4.20. **Монгол контент.** Монгол соёлын бүрдэл, агуулгыг шингээсэн бүтээлч үйлдвэрлэлийн нийгэм эдийн засгийн ач холбогдлыг нэмэгдүүлэн, олон улсын зах зээлд гаргахад бодлогоор дэмжлэг үзүүлнэ.

ТАВ. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГО

- 5.1. **Олон тулгуурт гадаад харилцаа.** Монгол улсын аюулгүй байдал, үндэсний язгуур эрх ашиг сонирхлыг улс төр, дипломатын аргаар тууштай хангаж, улс төржилтөөс ангид, нээлттэй, бие даасан, олон тулгуурт, гадаад бодлого хэрэгжүүлнэ.
- 5.2. **Сайн хөршийн харилцаа.** Хөрш хоёр улстай стратегийн түншлэлээ улам гүнзгийрүүлж уламжлалт, эв тэгш, сайн хөршийн найрсаг харилцааг бэхжүүлнэ.
- 5.3. **Гуравдагч хөршийн бодлого.** Энэхүү бодлогын хүрээнд бусад улстай хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ.
- 5.4. **Олон улсын идэвхтэй хамтын ажиллагаа.** Олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагаа, эдийн засаг, дэд бүтэц, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрт Монгол улсын оролцоог хангана.
- 5.5. **Визгүй чөлөөтэй зорчих боломж.** Монгол улсын иргэд гадаадад визгүй чөлөөтэй зорчих улсын тоог нэмэгдүүлэх бодлого баримтлана.
- 5.6. **Ногоон хөгжил – аюулгүй орчин.** Үндэсний аюулгүй байдлын хүрээнд байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах ногоон хөгжлийн чиг хандлагыг баримтлан, иргэдээ эрүүл, аюулгүй орчинд амьдруулах нөхцөлийг бүрдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллана.
- 5.7. **Байгаль орчноо хамгаалах хамтын ажиллагаа.** Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, байгалийн унаган төрх, биологийн янз байдлыг хамгаалах, цөлжилтийг сааруулах, учрах эрсдлийг бууруулах чиглэлээр олон улс, бүс нутаг, үндэсний байгууллагуудтай идэвхийлэн хамтран ажиллана.
- 5.8. **Хосолмол хөдөлгүүртэй автомашин.** Байгальд ээлтэй, эдэлгээний зардал зарцуулалт багатай хосолмол хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн хэрэглээг бодлогоор дэмжиж ажиллах санаачлага гаргана.
- 5.9. **Цэвэр орчин.** Агаар, ус, хөрсний бохирдлын хор хөнөөлийг арилгахад иргэд, орон нутаг, олон нийтийн байгууллагын санал санаачилгыг дэмжиж, УИХ, Засгийн газартай хамтарч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн үйл ажиллагааг чиглүүлэн ажиллана.
- 5.10. **Ус амин эрдэнэ.** Усны нөөцийн нэгдсэн менежментийг төлөвшүүлэх, усны эх, ундаргыг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, хэмнэх, дахин ашиглах, хүн амын эрүүл ахуйн шаардлага хангасан болон үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хүртээмжтэй хангах бодлогыг дэмжинэ.
- 5.11. **Хариуцлагатай уул уурхай.** Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж, орхигдсон газар нутгийг нөхөн сэргээх ажлыг буруутай этгээдээр бүрэн хийлгэх бодлого баримтална.

- 5.12. **Эрүүл хүнс.** Хүн амын хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний 70-аас доошгүй хувийг дотооддоо үйлдвэрлэх, хүнсний чанарын аюулгүй байдлыг олон улсын чанарын стандартад нийцүүлэх бодлого баримтална.
- 5.13. **Баталгаатай эм.** Эмийн үйлдвэрлэл, эм, эмнэлгийн хэрэгслийн импортын зохицуулалтыг сайжруулах, чанар, аюулгүй байдлын хангах бодлогыг Засгийн газартай хамтран хэрэгжүүлнэ.
- 5.14. **Батлан хамгаалах бодлого.** Батлан хамгаалах бодлогыг тууштай дэмжин, орон нутгийн хамгаалалтын үзэл баримтлалыг хуульчлан бүх нийтийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- 5.15. **Монгол цэрэг – Энхийн цэрэг.** Зэвсэгт хүчнийг мэргэжлийн хариуцлагатай удирдлага, мэргэшсэн бие бүрэлдэхүүнд суурилуулан хөгжүүлж, олон улсын энхийг сахиулах ажиллагаанд идэвхтэй оролцох бодлогыг үргэлжлүүлнэ.
- 5.16. **Зэвсэглэл, техникийн шинэчлэл.** Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийн шинэчлэлийг дэс дараатайгаар хийх, цэргийн байгууллагуудын уялдаа холбоо, чадавхыг нэмэгдүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.
- 5.17. **Хил хамгаалах чадамж.** Улсын хил хамгаалахад шаардлагатай хяналт, мэдээлэл, харилцаа холбоо, техник технологийн чадамжийг дээшлүүлнэ.
- 5.18. **Үндэсний иргэний хамгаалалт.** Газар хөдлөлт, гал, усны болон бусад болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх бүх нийтийн гамшгаас хамгаалах хөтөлбөрийг санаачилан, хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгоно.
- 5.19. **Болзошгүй эрсдэл – урьдчилан сэргийлэлт.** Бүс нутагт бий болж болзошгүй террорист ажиллагаа, түүнээс үүдэлтэй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн терроризмтой тэмцэх тогтолцоог боловсронгуй болгоно.
- 5.20. **Цахим аюулгүй байдал.** Кибер халдлагаас урьдчилан сэргийлэх үндэсний стратеги боловсруулж, иргэд, хувийн хэвшил, төрийн байгууллагуудын мэдээлэл, үйл ажиллагааг хамгаалах ажлыг шинэ түвшинд гаргана.
- 5.21. **Хар тамхины эсрэг хатуу тэмцэл.** Хар тамхи хэрэглэх, дамжуулах, худалдах, хүний наймааны гэмт хэрэгтэй хатуу тэмцэж, бүс нутгийн хамтын ажиллагааг өргөтгөнө.
- 5.22. **Дэлхийд танигдсан Монгол.** Монгол улсын түүх, соёлын өв, эдийн засаг, нийгэм соёлын ололт амжилт, гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагааг дэлхий нийтэд сурталчлан таниулах ажлыг мөрдлөг болгоно.

Миний бие Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдвол төрийн бодлогын залгамж чанарыг хадгалж, нийгмийн бүхий л салаа мөчрийн санал, оролцоог бүрнээ хангаж, УИХ, Засгийн газартай хүч хавсран энэхүү Мөрийн хөтөлбөрийн зорилтоо хэрэгжүүлнэ.

Мөрийн хөтөлбөрийнхөө хэрэгжилтийг өөрийн биеэр манлайлж, ам ажлын зөрүүгүй хэрэгжүүлж, жил бүр хийсэн ажлын тайлангаа УИХ, ард түмэндээ ил тодоор тайлагнах болно.